



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 08/03

Эрдэнэт

Дэд хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", 19 дүгээр зүйлийн 19.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн аялал жуулчлалыг 2017-2021 онд хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д ДААЛГАХ нь:

2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлах.

2.2.Шаардагдах хөрөнгийг 2018 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган батлуулах.

2.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын дүнг жил бүрийн IY улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнах.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА